



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 8 сарын 21 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот


Хуваарьт өөрчлөлт оруулах
тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналыг харгалзан Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 123 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2014 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь”-ийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Соёл, спорт аялал жуулчлалын сайд, Хууль зүйн сайд, Хөдөлмөрийн сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын багцын санхүүжилтийн сар, улирлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн сар, улирлын хуваарь”-ийг 2 дугаар хавсралтаар, мөн тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2014 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг шинэчилсэн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т зөвшөөрсүгэй.

САЙД



Ч.УЛААН